



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/Н19.

Улаанбаатар хот

Загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор баталсан “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ын 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан тухай актын загвар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Уул уурхайн зориулалтаар ашиглагдаж эвдэгдсэн газрын нөхөн сэргээлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Дэжидэд даалгасугай.



САЙД

Н. БАТЦЭРЭГ

011324

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын
Сайдын 2015 оны ~~8~~ дугаар сарын ~~16~~ ны өдрийн
А/419 тоот тушаалын хавсралт



“Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан тухай акт”-ын загвар

20... оны ... дугаар дугаар ...
сарын ... -ний өдөр

д/д	асуулт	
1.	Байршил Аймаг ,нийслэл: сум, дүүрэг: баг, хороо: газрын нэр:	
2.	Аж ахуйн нэгжийн нэр Хаяг: Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: регистр:	
3.	Тусгай зөвшөөрлийн Дугаар: Ордын нэр: Талбай /га-аар/:	
4.	“.....” ХХК-ий нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн албан тушаалтан: овог нэр: утас:	
5.	Нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжиж зураглал үйлдсэн мэргэжлийн байгууллагын нэр: хаяг:	
6.	Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар, үр дүн	
	Нөхөн сэргээлтийн хэмжээ <u>Нэг. Техникийн нөхөн сэргээлт</u> Талбайн хэмжээ /Га-аар/ Хийсэн ажлын хэмжээ /мян м ³ зэр/ Зардал /төгрөгөөр/ Хоёр.Биологийн нөхөн сэргээлт	

	Талбайн хэмжээ /Га-аар/ Тарьсан мод, ургамал /төрлөөр/ Зардал /төгрөгөөр/	
7.	Дүйцүүлэн хамгаал чиглэлээр гүйцэтгэсэн ажлын танилцуулга, үр дүн	
8.	Нэмэлт мэдээлэл /1:2000 масштабтай зураглал, шинжилгээний дүн, фото зураг, хүлээлгэн өгсний дараа хийх хяналт мониторингийн зардалтай холбоотой баримт материалыг хавсаргаж болно./	

Нөхөн сэргээлт хийсэн тухай
ДҮГНЭЛТ:

ТАЙЛБАР:

Нөхөн сэргээлтэд хамрагдсан талбай, хийсэн ажлын хэмжээг техникийн болон биологийн гэж ангилан хэмжилтийн дүнг үндэслэн тогтооно.
Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод бут, ургамлын төрөл зүйлийг тодорхой тусгана.

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга:

- аймаг /нийслэлийн /..... сум/дүүрэг/-ын Засаг дарга.....

/эсхүл томилогдсон албан тушаалтан/

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн

..... аймгийн сумын хэсгийн байгаль хамгаалагч

..... аймгийн сумын иргэдийн төлөөлөл

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

..... ХХК-ийн захирал

.....